


## Хавсралт 8. Ажлын даалгавар



СЭЛЭНГЭ АЙМАГ, ЕРӨӨ СУМ – БУГАНТ ТОСГОН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны сарын -ны өдөр	№	Сэлэнгэ аймаг, Ерөө сум
1. Зураг төсөл боловсруулах үндэслэл		Сэлэнгэ аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо байгаа Ерөө сум – Бугант тосгон чиглэлийн хайрган хучилттай авто замыг хатуу хучилттай авто зам болгон шинэчлэх
2. Байршил		Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгоны нутаг дэвсгэрт
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр		Улсын төсөв
4. Замын техникийн ангилал, замын зэрэг		2А-Хрз-ЗХГ-2-80 ангилалын Хуримтлуулагч зам (Хөдөлгөөний 2 зурвастай, зорчих хэсэг нь зааглагдаагүй, тооцоот хурд нь 80 км/цаг)
5. Замын эхлэлийн цэг		Ерөө сум
6. Замын төгсгөлийн цэг		Баянгол гүүр хүртэл
7. Замын хучилтын цэг		Одоо байгаа хайрган хучилттай авто замыг хатуу хучилттай болгох. Хучилтийн хийцийг зургийн

ерөнхий инженерийн техникийн шийдэл ба тооцоогоор сонгоно.

8. Төлөвлөлтийн норм

- “Авто зам төсөллөх” ЗЗНБД 22-004-2016
- “Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт” БНБД 30-01-04
- “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01\*/2006
- “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88
- “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS4597:2014
- “Авто замын тэмдэг, тэйдэглэл, гэрлэн дохио хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS4596:2014
- “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2006

10. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Нэг үе шаттай, 2021 оны 12 дугаар сард багтаан гүйцэтгэнэ

11. Зураг төслийн иж бүрдэл

- “Геодези зурагзүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах

шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан

- Буурь хөрс болон зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын тойм судалгааг багтаасан Инженер-геологийн хайгуул судалгааны ажлын тайлан
- Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:
  - Авто зам, хиймэл байгууламжийн ажлын иж бүрэн нарийвчилсан зураг төсөл
  - Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага;
  - Замын зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардал;
  - Ажилбар тус бүрийн болон Барилгын ажлын нэгдсэн тоо хэмжээ
  - Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ);
  - Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд;
  - Том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл
  - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт

12. Зураг төслийн байгууллага

“Эс Ар Пи Инженер Консалтинг Монголиа” ХХК

13. Захиалагч байгууллага

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг даргын тамгын газар

- Одоо байгаа хайрган хучилттай замыг хатуу хучилттай авто зам болгох
- Төлөвлөж буй авто зам нь одоо байгаа Ерөө сум – Бугант тосгон чиглэлийн хайргийн хучилттай авто замын трассаар явна.
- Ойролцоо өнгөрөх сумын төвүүдийг гол замтай холбосон холбоос замыг төсөллөх;
- Уулзвар ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх;
- Замын шаардлагатай хэсэгт түр зогсоол төсөллөх;
- Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Авто замын чиглэлийг сонгохдоо цас мөсний үйлчлэл, ус дулааны горим, гадаргуун ус зайлуулалт гэх мэтчилэн байгаль цаг уурын хүчин зүйлсийн үйлчлэлийг судлах, судалгааны үр дүнг үндэслэн далангийн хийцийг төсөллөх;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах;
- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;


- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлалд оруулна.

Хянасан:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг даргын тамгын газрын дарга

Боловсруулсан:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны захирагч



С.ЦЭВЭЛМАА



Д.ЭРДЭНЭБУЛГАН